

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар  
сарын 25-ны өдрийн А/258 дугаар  
тушаалын хавсралт

## **МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

# **БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

2023 он

[ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ]

## БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

[СУРАГЧДЫН ДАДЛАГЫН ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛ  
НИЙЛҮҮЛЭХ]

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

[ХЭАПК/20240102001]

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ.....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах.....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	3
11. Тендерийн иж бүрдэл.....	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	5
13. Хувилбарт санал.....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага.....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	8
20. Тендерийн валют.....	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа.....	9
22. Тендерийн баталгаа.....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх.....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	10
25. Тендерийн талаар тодруулга авах.....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох.....	11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....	11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	11

32.	Тендерийг эрэмбэлэх .....	11
33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	11
34.	Мэдэгдэл хүргүүлэх .....	11
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	12
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	12

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
  - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
  - 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
  - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
  - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
  - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
  - 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

## **Б.АГУУЛГА**

**9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:  
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;  
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;  
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;  
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;  
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;  
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

**11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

**В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
  - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
  - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
  - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
  - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
  - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
  - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
  - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
  - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
  - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
  - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.



- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн маягтууд жишиг**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

**Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

**27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

**29. Тендерийг үнэлэх**

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

**30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг магадлах дахин**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн  
баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг  
зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.



## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <i>[Хэнтий аймаг дахь Политехник коллеж]</i>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр <i>[Сурагчдын дадлагын хичээлийн материал нийлүүлэх]</i>
<b>ТШЗ 1.1</b>	Тендерийн урилгын дугаар: <i>[ХЭАПК/20240102001]</i>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: Барилгын материал</i> <i>Багц № 2: Гар урлалын материал</i> <i>Багц № 3: Хөдөө аж ахуйн материал</i> <i>Багц № 4: Оёдол, үсчин гоо сайхны материал</i> <i>Багц № 5: Хүнсний материал</i> <i>Багц № 6: Авто сэлбэгийн материал</i> <i>Багц № 7: Бичиг хэргийн материал</i> <i>Багц № 8: Хөдөлмөр хамгааллын материал</i> <i>Багц № 9: Хичээлийн хэрэглэгдэхүүн</i> <i>Багц № 10: Ном, сурах бичиг</i>
<b>ТШЗ 1.4</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <i>["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих].</i>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>[Улсын төсвийн хөрөнгө]</i>

ТШЗ 2.1	<p>Нийт төсөвт өртөг: <b>[175 259 000]</b></p> <p><b>Багц № 1: Барилгын материал 50 292 034</b></p> <p><b>Багц № 2: Гар урлалын материал 8 621 200</b></p> <p><b>Багц № 3: Хөдөө аж ахуйн материал 5 389 050</b></p> <p><b>Багц № 4: Оёдол, үсчин гоо сайхны материал 7 319 120</b></p> <p><b>Багц № 5: Хүнсний материал 8 224 650</b></p> <p><b>Багц № 6: Авто сэлбэгийн материал 10 145 260</b></p> <p><b>Багц № 7: Бичиг хэргийн материал 45 308 344</b></p> <p><b>Багц № 8: Хөдөлмөр хамгааллын материал 12 979 650</b></p> <p><b>Багц № 9: Хичээлийн хэрэглэгдэхүүн 22 107 675</b></p> <p><b>Багц № 10: Ном, сурах бичиг 4 872 017</b></p>
<b>Б. АГУУЛГА</b>	
ТШЗ 8.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: <b>[Хэнтий аймаг дахь Политехник коллеж]</b></p> <p>Хаяг: <b>[Хэрлэн сум 4-р баг, Политехник коллежийн 206-р өрөө]</b></p> <p>Утасны дугаар: <b>[70563012, 70563020]</b></p> <p>Цахим шуудангийн хаяг: <b>[Khentii.ptc.mn]</b></p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>[“Үгүй”]</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>[“Монгол хэл”]</b>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>[“Зөвшөөрөхгүй”]</b>
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: <b>[“Үгүй”]</b>
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: <b>[“Үгүй”]</b>
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: <b>[“Шаардахгүй”]</b></p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: <b>[“Шаардлагатай”]</b></p>

	<p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: <b>[“Шаардахгүй”]</b></p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>[Борлуулалтын орлогын хэмжээ: [ 2023 оны нийт борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн багцийн үнийн дүнгээс багагүй байна.]</b></p> <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: <b>[Сүүлийн 1 жилийн (2023 оны) ижил төстэй ажил гүйцэтгэсэн жагсаалт ]</b></p>
<b>ТШЗ 18.2</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>[“Шаардана”]</b>
<b>ТШЗ 19.1</b>	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <b>[“Тийм”]</b></p> <p><b>Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Харилцагч банкны мэдэгдэл;</li> <li>- сүүлийн 1 жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;</li> </ul>
<b>ТШЗ 20.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b>[“Тийм”]</b></p> <p><b>- Оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</b></p>
<b>ТШЗ 21.5.</b>	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>[“Тохируулахгүй тогтмол байна”]</b>
<b>ТШЗ 21.6</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>[“Үгүй”]</b>
<b>ТШЗ 24.1</b>	<p>Тендерийн баталгааны дүн: 876 295 төг <b>[Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувь]</b></p> <p><b>Багц № 1: Барилгын материал 251 460 төг</b></p> <p><b>Багц № 2: Гар урлалын материал 43 106 төг</b></p> <p><b>Багц № 3: Хөдөө аж ахуйн материал 26 945 төг</b></p> <p><b>Багц № 4: Оёдол, үсчин гоо сайхны материал 36 596 төг</b></p> <p><b>Багц № 5: Хүнсний материал 41 113 төг</b></p> <p><b>Багц № 6: Авто сэлбэгийн материал 50 726 төг</b></p> <p><b>Багц № 7: Бичиг хэргийн материал 226 542 төг</b></p> <p><b>Багц № 8: Хөдөлмөр хамгааллын материал 64 898 төг</b></p> <p><b>Багц № 9: Хичээлийн хэрэглэгдэхүүн 110 538 төг</b></p> <p><b>Багц № 10: Ном, сурах бичиг 24 360 төг</b></p>

### Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <b>1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;</b> <b>2. Улсын бүртгэлийн гэрчилгээ</b>
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>[2024. 02. 26]</b> Цаг: <b>[14: 00] өмнө <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягаар ирүүлнэ.</b>
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <b>[2024. 02. 26 ]</b> Цаг: <b>[14:30]</b> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>[Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг Политехник коллежийн 206 тоот өрөө]</b>
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b>	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>[“Үгүй” ]</b>
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: <b>[Орон нутагт үйлдвэрлэл явуулж байгааг илтгэсэн баримт бичиг, нотлох зураг, видео бичлэг]</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

*[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.*

*Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.*

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*

#### **Зураг, төсөл**

*Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.*

## **Шалгалт, туршилт**

*[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.*

*Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.*

*Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]*

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
<b>Багц -1</b>	<b>Барилгын материал</b>	<p>Нийлүүлэгдэх барилгын материал нь стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлж буй барилгын материал, гар багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь бүгд шинэ байна.</li> <li>• Ус чийг нэвтрээгүй, эмтэрч, хэмхрээгүй, хадгалалтын горим алдагдаагүй /эмульс, цавуу зэрэг материал нь хөлдөөгүй байх.../ байх шаардлагатай</li> <li>• Хүний биед хоргүй стандартын шаардлага хангасан сургалт явуулахад нийцсэн байна.</li> <li>• Шаардлага хангаагүй материал, багаж хэрэгслийг захиалагч тал нийлүүлэгч талд эргүүлэн өгч сургалт явуулахад шаардлага хангахуйц материалаар солин авна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар бараа материал багаж тоног хэрэгслийг гэрээнд заасан графикийн дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.Эрүүл ахуйн шаардлага хангасан хүний биед хоргүй</li> <li>• Нийлүүлж буй цахилгааны материал, багаж хэрэгсэл, бүгд шинэ байна.</li> <li>• Стандартын шаардлага хангасан сургалт явуулахад нийцсэн байна.</li> <li>• Шаардлага хангаагүй материал, багаж хэрэгслийг захиалагч тал нийлүүлэгч талд эргүүлэн өгч сургалт явуулахад шаардлага хангахуйц материалаар солин авна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар бараа материал багаж тоног хэрэгслийг гэрээнд заасан графикийн дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.Эрүүл ахуйн шаардлага хангасан хүний биед хоргүй</li> </ul>
<b>Багц 2</b>	<b>Гар урлал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Янз бүрийн толбогүй ,гэмтэлгүй</li> <li>• Утас нь нягтрал сайтай байна</li> <li>• Эсгий нягтрал сайтай,цоорхойгүй, үйлдвэрийн бүтээгдэхүүн байна</li> </ul>

<b>Багц- 3</b>	<b>Хөдөө аж ахуйн материал</b>	<p>Нийлүүлэгдэх багаж техник материал нь стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлж буй материал, гар багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь бүгд шинэ, зэврэхгүй материалаар хийгдсэн байна.</li> <li>• Чанарын шаардлага хангасан хадгалалтын хугацаан дуусаагүй байх сав баглаа боодол бүрэн бүтэн байна.</li> <li>• Шаардлага хангаагүй материал, багаж хэрэгслийг захиалагч тал нийлүүлэгч талд эргүүлэн өгч сургалт явуулахад шаардлага хангахуйц материалаар солин авна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар бараа материал багаж тоног хэрэгслийг гэрээнд заасан графикийн дагуу хүргэж ирнэ.</li> </ul>
<b>Багц 4</b>	<b>Оёдол, үсчин гоо сайхны материал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлж буй гоо сайхны бараа нь стандартын шаардлага хангасан, баталгаатай бүтээгдхүүн байна.</li> <li>• Хугацаа хэтрээгүй байна.</li> <li>• Салоны зориулалттай байна.</li> <li>• Сөрөг үр дагаваргүй, хүний биед харшил үзүүлэхгүй байна.</li> <li>• Ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар бараа материалыг гэрээнд заасан графикийн дагуу хүргэж ирнэ.</li> </ul> <p>Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан</p> <ul style="list-style-type: none"> <li>• индүүлэг сайн авдаг.ширхэггүй,эрүүл ахуйн шаардлага хангасан</li> <li>• Угаахад будаг гардаггүй,агшдаггүй</li> <li>• Ор хөнжил,дэрний зориулалтай даавуу нь бөөсдөггүй,эрүүл ахуйн шаардлага хангасан байна.</li> </ul> <p>Оёдлын утас нь амархан тасардаггүй байна</p>
		<p>Ерөнхий зүйл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Зориулалтын сав, баглаанд савласан байна.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> </ul>



<p><b>Багц -5</b></p>	<p><b>Хүнсний материал</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх</li> <li>• Лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.</li> <li>• Хорхойнд идэгдээгүй байх</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Лабораторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна.</li> </ul> <p><b>2.1 Барааны нэр: Төмс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төмсний диаметр 6-7 багагүй, 1ш төмсний дундаж жин 180-250 гр байх</li> <li>• Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.\гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх\</li> <li>• Стардартын шаардлага хангасан үрээр тарьсан байх.\Хятад үрийн төмсөөр тариагүй байх\</li> <li>• 1тн төмс бүрт 10 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний төмс нэмж нийлүүлэх</li> </ul> <p><b>2.2 Барааны нэр: Байцаа</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Байцаа нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй,ялзраагүй байх.</li> <li>• Байцааны дундаж жин нь 2-2.5кг байх</li> <li>• Гадаргууны илүүдэл навч, голыг цэвэрлэсэн байна.</li> </ul> <p><b>2.3 Б Барааны нэр: Бөөрөнхий сонгино</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ялзарч муудаагүй,хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.</li> <li>• Орон нутагт тариалсан байна.</li> <li>• Соёлж, хөгшрөөгүй байхаас гадна 1ш сонгины дундаж жин 100-150гр байх.</li> <li>• 100кг сонгино бүрт 2 кг хорогдол тооцож байх</li> </ul> <p><b>2.3 Лууван</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 1 ш луувангийн дундаж жин 200-300 гр байх ба механик элдэв хольцгүй,зөөлөрч муудаагүй,чийгээ алдаагүй соёолоогүй,гадны үнэр амтгүй байна.</li> <li>• Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай улбар шар өнгөтэй байна.</li> <li>• 100кг лууван бүрт 2 кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний лууван нэмж олгоно.</li> </ul> <p><b>2.4 Барааны нэр: Манжин</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Шар, хүрэн манжин нь стандартын шаардлага хангасан байна.</li> </ul>
-----------------------	--------------------------------	--

		<ul style="list-style-type: none"> <li>• Гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй, шинэ байна.</li> <li>• Гадаргууны шороо, үндэс, навчиг бүрэн цэвэрлэсэн байх</li> </ul> <p><b>Барааны нэр: Нарийн ногоо</b> \өргөст хэмх, улаан лооль, чинжүү, цэцэгт байцаа\</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэт хөгшрөөгүй, чийгээ алдаагүй, хөгц үүсч муудаагүй, шинэ байна.</li> <li>• Өргөст хэмх нь цайвар ногоон өнгөтэй гашуун биш байна.</li> <li>• Дундаж жин нь 250-280гр, 4-5 см диаметртэй байна,</li> <li>• Улаан лооль нь бяцарч гэмтээгүй, хэт исгэлэн гашуун биш, болц гүйцсэн байх.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• 2013 оны “Хүнсний хууль”-ийг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Лабораторийн шинжилгээний болон гарал үүслийн Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Зориулалтын сав, баглаанд савласан байна.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• 2013 оны хүнсний хуулийг хэрэгжүүлсэн байна.</li> <li>• Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх</li> <li>• Лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</li> <li>•</li> </ul> <p>Барааны нэр: Будааны төрөл (цагаан, шар, хүүхдийн будаа,)</p> <ul style="list-style-type: none"> <li>• MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна.</li> <li>• Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, бяцарч хуваагдаагүй байна.</li> <li>• Цагаан будаа нь том ширхэгтэй, агшаахад нялцаахгүй байх</li> <li>• 25кг-аар савлагдсан байх</li> </ul> <p>Барааны нэр: Элсэн чихэр</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гадны үнэр амтгүй, механик хольцгүй байна.</li> </ul>
--	--	---

		<ul style="list-style-type: none"> <li>• Чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, шарлаагүй байна.</li> <li>• 50кг-аар савлагдсан байна.</li> </ul> <p>Барааны нэр: Масло</p> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Тослогийн хэмжээ 82 %-аас багагүй байна.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (хайлаагүй, хөгцгүй, элдэв өнгө амт үнэргүй байна)</li> <li>• Цаасан хайрцаганд 20кг-аар савлагдсан калькин цаасанд боодолтой байх</li> </ul> <p>Барааны нэр: Ургамлын тос</p> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. ( элдэв өнгө амт үнэргүй байна)</li> <li>• 1л болон 5л-ээр савлагдсан байх</li> </ul> <p>Барааны нэр: Бусад хүнс</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Исгэгч</li> <li>➢ Амтлагч / 200гр-аар савлагдсан супер амтлагч байх ба монгол заавартай/</li> <li>➢ Томат 400гр савлагаатай улаан өнгийн лаазтай/</li> <li>➢ Хуурай цай (гүрж ногоон цай</li> <li>➢ Жигнэмэг ( цайны печень вафли гэх мэт)</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна</li> <li>• Лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</li> <li>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (хөгц амтгүй байна.)</li> </ul>
--	--	---

		<p>Барааны нэр: Гоймонгийн төрөл</p> <p>Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.</p> <p>5 кг-аар савлагдсан, хөгцөрч муудаагүй, үүрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй, шинэ байна.</p> <p>Өндөгний хольцтой, урсамтгай биш шинж чанартай байна.</p> <p>Барааны нэр: Гурил</p> <ul style="list-style-type: none"> <li>• MNS0244:2009 техникийн шаардлага хангасан байна.</li> <li>• Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.</li> <li>• 1-р зэргийн гурил нь БГ-085 хангасан байна.</li> <li>• Дээд гурил нь БГ-055 хангасан байна.</li> <li>• 25 - 50 кг-аар савлагдсан</li> <li>• Чийгээ алдаагүй, чанар сайтай байна.</li> </ul> <p>Барааны нэр: Давс</p> <ul style="list-style-type: none"> <li>• 0.5 - 1 кг-аар савлагдсан, чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, иодын агууламж нь зохих түвшинд байна.</li> </ul>
Багц 6	Авто сэлбэг	<p>Нийлүүлэгдэх багаж техник материал нь стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийлүүлж буй авто машины сэлбэг нь чанарын шаардлага хангасан заагдсан стандартын дагуу байна.</li> <li>• Тухайн сэлбэг нь шинэ байх ба захиалганд дурдагдсан машинд тохирхоор байна.</li> <li>• Явах эд ангийн дугуй нь тухайн улиралын шаардлагад нийцсэн байх.</li> <li>• Шаардлага хангаагүй материал, багаж хэрэгслийг захиалагч тал нийлүүлэгч талд эргүүлэн өгч сургалт явуулахад шаардлага хангахуйц материалаар солин авна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар бараа материал багаж тоног хэрэгслийг гэрээнд заасан графикийн дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Багаж тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагаатай элдэв гэмтэл согоггүй байх</li> </ul>

Багц 7	Бичиг хэргийн материал	<p>Нийлүүлэгдэх бичгийн хэрэгсэл стандартын шаардлага хангасан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бичгийн цаас, өргөмжлөлийн цаас,люминаторын цаас нь нь нягтшил сайтай чанарын шаардлага хангасан бүгд баглаа боодолтой шинэ байна.</li> <li>• Канон, Принтерийн хор сайн чанарын бүгд баглаа боодолтой, шинэ хор байна.</li> <li>• Цаас зүсэгч,үдээс авагч, дугаарлагч нь сайн чанарын шинэ байна.</li> <li>• Нуруу, хавтасны тавиур нь чанарын шаардлага хангасан шинэ байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар бараа материал хэрэгслийг гэрээнд заасан графикийн дагуу хүргэж ирнэ.</li> </ul> <p>Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна</p>
Багц 8	Хөдөлмөр хамгаалал	<ul style="list-style-type: none"> <li>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.</li> <li>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.</li> <li>• Зориулалтын сав, баглаанд савласан байна.</li> <li>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.</li> <li>• Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх</li> <li>• Лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</li> </ul>
